

ЕБС-ИЙН БАГШ НАРЫН ХИЧЭЭЛД АНАЛИЗ ХИЙСЭН БАЙДАЛ

М.Баярсайхан¹

¹Ховд их сургууль

bayarsaikhan.khu@gmail.com

Хүлээн авсан огноо: 2021.10.21

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Ц.Нандинсүрэн

Хураангуй

Хичээл нь сургалт хүмүүжлийн ажлын зохион байгуулалтын нэг үндсэн хэлбэр юм. Хичээл нь сургалтын үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлнэ. Гэтэл өнөөгийн нийгэмд хичээлийг шинжлэх ухааны шаардлага хангасан өндөр төвшинд бүрэн дүүрэн зохион байгуулж чадаж буй эсэх талаар тодорхой үнэлгээ үгүйлэгдэж байгаа билээ. Иймээс бид энэхүү судалгааны ажлын өмнө уламжлалт болон орчин үеийн хичээлийн хоорондын ялгааг илрүүлж орчин үеийн хичээлийн технологийн онцлогийг судлах аргачлал боловсруулах зорилго тавьсан. Анхны сургууль байгуулан сургалтын зохион байгуулалтын шинэ хэлбэр анги-хичээлийн зохион байгуулалт бий болсон нь монгол соёл-иргэншлийн хувьд цоо шинэ зүйл байсны хувьд сургуулийн биш монголын уламжлалт сургалтын нэр хүндийг устгах, үл ойшоох тал нь хүмүүсийн сонирхол татах болов. Хичээлийн зорилго хүмүүст бичиг үсэг сурах шинжлэх ухааны мэдлэгийг тогтооход чиглэж байсан. Орчин үеийн хичээлийг Оросын эрдэмтэн өөр өөрсдийн үзэл бодлоо янз бүрээр илтгэж байсан. Эдгээрийг заримыг нь тодруулан авч үзвэл: **С.Мягченко** "Хичээл нь сурагчдын анхаарлыг татаж сэтгэлийг нь хөдөлгөж байх мэдлэг олгох ёстой" хэмээн үзэж байсан. Хэдийгээр сүүлийн жилүүдэд технологийн шинэчлэл хийгдэж байгаа боловч төдийлөн бид бүхний хүсэн хүлээсэн үр дүнд хараахан хүрээгүй байгаа билээ. 1999 оноос эхлэн сургалтын технологийн шинэчлэл, ээлжит хичээлийн чанар үр дүн зэргүүдээр сургалт семинар их зохиогдож байгаа боловч тодорхой ахиц дэвшил гарахгүй байна. Ийм учраас зөвхөн сургууль багш нар төдийгүй, багш бэлтгэдэг сургуулийн сургалтанд сургалтын технологийн шинэчлэлийн онол арга зүйн үндсийг авч үзэхийн зэрэгцээ түүний менежментийн асуудлыг тодорхой авч үзэх шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Түлхүүр үг: Сургалт, арга зүй, хандлага, чиглэл

Үндэслэл

Хичээлийн тухай ойлголт, тулгуур онол

Анхны сургууль байгуулан сургалтын зохион байгуулалтын шинэ хэлбэр анги-хичээлийн зохион байгуулалт бий болсон нь монгол соёл-иргэншлийн хувьд цоо шинэ зүйл байсны хувьд сургуулийн биш монголын уламжлалт сургалтын нэр хүндийг устгах, үл ойшоох тал нь хүмүүсийн сонирхол татах болов. Хичээлийн зорилго хүмүүст бичиг үсэг сурах шинжлэх ухааны мэдлэгийг

тогтооход чиглэж байсан. Монголчууд лам багшаа хүндлэн тангад номоо их хэмжээгээр цээжлэж байсан онцлог нь, мал маллагааныхаа явцад олж удамшиж ирсэн. Хүүхдэд багаас нь хөгжсөн тогтоох ойд түшиглэн хичээл өндөр үр дүнд хүрч байлаа. Улс орон даяар хичээлийн нэг л заах арга шүтэн боловсролын бүх байгууллага голдуу л байцаан шалгах зорилготой байж хичээлийн холимог хэлбэрээ багш нараас хатуу шаарддаг байлаа. Аль ч хичээлд багш заавал хоёр, гурван сурагчаар өнгөрсөн 3 хичээл яриулж хэр тогтоосныг нь шалгаж дүн тавина.

Уламжлалт хичээл нь:

- Сурагчдад танин мэдэх бие даасан үйл ажиллагаа сэтгэх арга барил биш, зөвхөн ихийг тогтоолгох
- Заах арга барилын хувьд нэг хэвийн догматик (тууштай баримтлах) шинжтэй учир хүүхийг мөн ийм хэвшилд сургах
- Хүүхдийн бие даах чадварт анхаарахгүй зэрэг үндсэн дутагдалуудтай байсан юм.

Хичээл нь дараах зүйлстэй салшгүй холбоотой байдаг гэж доктор Л. Жамц үзсэн байдаг.

- Багшийн гадаад байдал
- Багшийн зан ааш
- Хичээлд бэлтгэх тухай
- Хичээл эхлэх тухай
- Асуух
- Шинэ материал заах
- Заасан зүйлийг батагах гэсэн хэсгүүдээс бүрддэг гэж үзэж байсан.

Хичээл гэдэг бол хүүхэд залуусыг сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх зорилго бүхий тодорхой цаг хугацаанд тогтсон бүрэлдхүүнтэйгээр явагддаг багш сурагчдын хамтын идэвхитэй бүтээлч үйл ажиллагаа юм. Бүх шатны сургуульд хичээл нь сургалт-хүмүүжлийн ажлыг зохион явуулах үндсэн хэлбэр нь болдог.

Хичээлийн тухай эрдэмтэдийн үзэл онол

Орчин үеийн хичээлийг Оросын эрдэмтэн өөр өөрсдийн үзэл бодлоо янз бүрээр илтгэж байсан. Эдгээрийг заримыг нь тодруулан авч үзвэл: **С.Мягченко** "Хичээл нь сурагчдын анхаарлыг татаж сэтгэлийг нь хөдөлгөж байх мэдлэг олгох ёстой" хэмээн үзэж байсан. **В.Ананьин** "Хичээл

бол сурагчдыг өөрснөө бодож ажиллаж, ухааран ойлгох ажлаас чөлөөлж хэрхэвч болохгүй зүйл юм” гэж үзсэн байсан. **Н.Кодак** “Хичээлийг ямар багш зааж байгаагаас хичээл нь шууд хамаардаг” Багш хүн нэгэнт бусдыг сургадаг учраас ганцхан мэргэжлээрээ биш олон талын өргөн мэдлэгтэй тэр мэдлэгээ бусад хичээлүүдтэй холбож, сурагчиддаа өргөн мэдлэгийг олгож чаддаг, заах арга зүйн уран чадвартай байхыг шаарддаг юм. **Х.Кристостурьян** “Хичээлийн гол чухал элемент нь сурагчдын бие даасан ажил хийж, түүнийхээ үр дүнгээр өөрөө олгож авдаг чадвартай болоход оршиж байдаг”. **Л.Пресман** “Хичээл гэдэг нь орчин үеийн техник хэрэгслийн тусламжтайгаар явагддаг түүнийг заах арга барилыг боловсруулах нь чухал”. **А.Дорошенко** “Хичээлийн гол элемент нь хичээлийн хэлбэр агуулга юм. Үүнийг сайн тогтоож өгөх хэрэгтэй байдаг”. **Д.Хабиб** “Сургалтанд сурагчдыг барьж сургах чиглэл ноёрхсоор байна. Энэ бол сайн сурагчдыг дунд сурагчдын хэмжээнд барьж, сул сурагчид дунд түлхэж буй асуудал юм. Хичээл нь хамгийн гол нь сайн сурагчдыг оюуны чадлын хэмжээгээр ахиулан сургах хөгжүүлэхэд чиглэж байх ёстой юм”. **Л.Толстой** “Сурагчдын идэвхи сонирхлыг хөгжүүлж сургах нь хичээлийн гол зорилго юм”. **Ю.Айхенвалд** “Хичээлийн зохион байгуулалтыг зөвхөн сурган хүмүүжүүлэх талаас биш бас эрүүл ахуйн эрхэм зүйлийг оролцуулж ярих маш чухал” хэмээн тус тус үзэж байсан. Эндээс дүгнэж үзэхэд орчин үеийн хичээл гэдэг нь “Сурагчдын идэвхи сонирхлыг өрнүүлж тэдний хооронд бүтээлчээр мэдлэг, чадвар, дадал бий болгодог бүтээлч үйл ажиллагаа” гэж хэлж болох юм. Хүүхдийн хөгжлийн асуудлаар зөв төсөөлөл авахад **Л.С.Выготский** хөгжлийн бүсийн онол тустай. Энэ онол нь:

- Хүүхэд тухайн насандаа бэлэн байгаа мэдлэг, чадварынхаа хүрээнд өөрөө хийж гүйцэтгэх хэмжээндээ шилжсэн төвшин буюу идэвхитэй хөгжлийн бүсэд (ИХБ) амьдарч байна. Идэвхитэй хөгжлийн бүсэд нь хүүхдийн өнөөдрийн амьдралыг тусгах бөгөөд маргааш шилжин орж болох амьдралын урьдчилсан бэлтгэл болно.
- ИХБ-ийн эргэн тойронд хүүхдийн маргаашийн хөгжлийн төвшинг харуулах ойрын ирээдүйн хөгжлийн бүс (ОИХБ) байна. Сургах үйл явцад нөхцөл бүрдсэн тохиолдолд тодорхой хугацааны дараа хүүхэд ойрын ирээдүйн хөгжлийн бүс рүүгээ шилжин орж өөрийнхөө хөгжлийн хувьд алхалт хийнэ. Шинээр шилжин орсон ойрын ирээдүйн хөгжлийн бүс нь хүүхдийн идэвхитэй хөгжлийн бүс болон «хувирч» түүний орчинд ойрын ирээдүйн хөгжлийн шинэ бүс үүсэх бөгөөд түүн рүү дахин алхах замаар дараачийн шинэ төвшинд шилжих, дахин ойрын ирээдүйн хөгжлийн шинэ бүс үүсэх замаар хөгжил үргэлжилнэ.

Сургалтын технологи-хичээлийн технологийн тухай

Сурган хүмүүжүүлэх аливаа үзэгдлийг онол, практик, арга зүй, туршлагын төвшинд судалснаар боловсролын салбар дахь аливаа шийдэл улам бүр амьдрал, бодит байдалд ойртох болно. Хэт хийсвэр онолын дүгнэлт, үзэл санаа, мэдлэг нь шууд хэрэглээ болдоггүй учраас түүнийг заах арга зүйн төвшинд түгээмэл байдлаар шилжүүлж, улмаар төгс боловсронгуй технологиор хэрэгжүүлбэл үр дүнд хүрэх нь зайлшгүй.

Технологи гэдэг нь: Сургах урлаг судлал буюу сургах, сурах, арга ажилбар, эрэмбэ тогтолцоог тэмдэглэсэн ухагдахуун юм. Японы эрдэмтэн сурган хүмүүжүүлэгч Т.Сакамото “Сургалтын технологи гэдэг нь боловсролыг буюу анги дахь сургалтыг системчлэх гэж нэрлэж болох сэтгэхүйн системчлэх аргыг сурган хүмүүжүүлэх ухаанд нэвтрүүлэх явдал” юм.

Сургалтын буюу хичээлийн технологи: Сургах зүй, сурган хүмүүжүүлэх, болон удирдлагын ухааны зүй тогтолд тулгуурлан боловсруулсан аливаа үйлийг гүйцэтгэх хамгийн оновчтой эрэмбэ, дэс дараа түүний хувилбар юм. Энэ утгаараа технологи гэдэг нь боловсролын салбарт бол хүнийг хүн болгон төлөвшүүлэх өвөрмөц урлаг: Сургалт хүмүүжлийн ажлын оновчтой, үр бүтээлтэй зохион байгуулахад мэдээллийн болон хяналтын техник хэрэгсэл ашиглах үйл явц нөгөө талаас сэтгэн бодох, танин мэдэх үйлдлийг системчлэх загварчлал юм.

Хичээлийн технологи

Хичээлийн хэсэг бүхэн ерөнхий болон тухайн зоригжуулсан байна.

Ерөнхий зорилго нь хичээлийн тодорхой үр дүнд төгсгөхөд чиглэгдэнэ. Тухайн зорилго нь хичээлийн тодорхой хэсгийн гол зорилго нь юм. Шинэ мэдлэг эзэмшихэд зайлшгүй суурь мэдлэгийг сэргээн хэрэглэхэд бэлэн болгох гэсэн тухайн зорилго хэрэгжих алхам болно. Харин зөвхөн хэрэгтэй тэр зүйлийг сэргээж бэлэн болгож өгнө гэсэн утгаараа тухайн зорилгоо биелүүлнэ. Хичээлийн хэсэг бүхэн нь бие биетэйгээ салшгүй гинжин холбоотой юм.

Орчин үеийн хичээлд тавигдах шаардлага.

Хичээлийг зөв зохион байгуулах үндэс болсон шаардлагуудыг баримтлснаар багш сурагчдын ашигтай үйл ажиллагааны коэффициент улмаар тэдний бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх боломж олж авна. Эдгээр шаардлага нь бүхэлдээ хичээлийн бүтцийг оновчтой болгоход багш чиг баримжаа болж хичээлийг цэгцтэй болгож үр дүнг дээшлүүлэх бололцоо олгоно. Үүний хамтад тэр шаардлагын цогцолбор нь хичээлийн чанарын шалгуур болж чадна. Сурган хүмүүжүүлэх практик тэргүүн туршлага шинжлэх ухааны шинэ ололт амжилт зүй тогтолд үндэслэн хичээлийг зохион байгуулахдаа:

- Дидактик дүрэм зарчмуудыг хэрэгжүүлэх
- Сурагчдын сонирхол ба хэрэгцээнд тулгуурлан тэдний бүтээлч танин мэдэх үйл ажиллагааг хангах
- Бие хүний бүх талыг хөгжүүлж төлөвшүүлэх сэдэл тэмүүлэл бий болгох
- Сурган хүмүүжүүлэх хэрэгслүүдийг бүтээлчээр ашиглах
- Оюун ухааны үйл ажиллагааны арга барил эзэмшүүлэх
- Хичээл бүрийг нягт нямбай төлөвлөх ба оношлох
- Хичээлийн үр өгөөж үр дүн нь түүнд тавигдах сургах хүмүүжүүлэх шаардлагатай зүй ёсоор холбогдож явагдана.

Хичээлд дүн шинжилгээ хийх буюу хичээлийн анализ

2.1 Хичээлд анализ хийх тухай

Хичээл бол сурган хүмүүжүүлэх үйлдвэрлэлийн үндсэн нэгж учраас хичээлд анализ хийх явдал нь удирдлага, хяналт шалгалтыг нэгжид төвлөрүүлж байгаа хэрэг юм. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны бүх тал хичээлээр процессоор хэрэгжиж байдаг учраас хичээлд анализ хийх нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны бүх талд анализ хийхтэй дүйх их ажил юм. Хичээлд анализ хийх дараах төрлийн хувилбар байдаг.

1. *Хичээлд анализ хийх ажлын гол зорилго нь:* Тэргүүн туршлага олж дэлгэрүүлэх, багшид туслах сургуулийн удирдлагыг анхаарах, хариуцан олж бэлтгэх чухал хэрэгцээт зүйлийг мэдэж авах, үндсэн үйлдвэрлэлийнхээ чанар, үр дүнг мэдэх, сайжруулах арга замыг эрж олох, бүх багш нарын шаардлагыг жигдрүүлэх, үзэл санааны нэгдлийг бий болгох зэрэг болно.

2. *Хичээлд суухдаа ажиглах, судлах зүйлсийн чиглэл:* Хичээлийн зорилго, агуулга, зохион байгуулалт, бүтэц, хэрэгсэл, боловсрол олгох, хөгжүүлэх, хүмүүжүүлэх нөлөө, багшийн мэдлэг, арга, ур чадвар, эв дүй, барил, шаардлага, үлгэр дууриал, туршлага, сурагчдын сонирхол, идэвхи, оролдлого, үйл ажиллагаа, мэдлэг, чадвар, багш сурагчдын харилцаа зэрэг болно.

Багш бүр өөрийнхөө болон бусад багш нарын хичээлд дүн шинжилгээ хийж сурах нь сургалтын чанарыг дээшлүүлэх, түүнийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой.

Хичээлд анализ хийх аргачлал

Орчин үеийн хичээлд сэдэлжүүлэлт хийж сурагчдын анхаарал сонирхлыг хичээлд татах нь хамгийн гол зүйл болж байгаа билээ. Хичээлд сэдэлжүүлэлт хэр хийсэн байдлыг зүйлээр тодруулж болно. Судлаж буй сэдвийн дагуу сурагчдын сонирхлыг татсан сурагчдыг идэвхжүүлсэн асуудлыг хөндөж хичээлд татан оролцуулсан байдал. Сургалтанд багш сурагчдын хэний үйл ажиллагаа давамгайлж байгааг дараах шалгуур үзүүлэлтээр гаргаж болно. Судалгааны

чухал нь: Хичээл нь сургалт хүмүүжлийн ажлын зохион байгуулалтын нэг үндсэн хэлбэр юм. Хичээл нь сургалтын үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлнэ. Гэтэл өнөөгийн нийгэмд хичээлийг шинжлэх ухааны шаардлага хангасан өндөр төвшинд бүрэн дүүрэн зохион байгуулж чадаж буй эсэх талаар тодорхой үнэлгээ үгүйлэгдэж байгаа билээ. Иймээс бид энэхүү судалгааны ажлын өмнө уламжлалт болон орчин үеийн хичээлийн хоорондын ялгааг илрүүлж орчин үеийн хичээлийн технологийн онцлогийг судлах аргачлал боловсруулах зорилго тавьсан.

Зорилт

Судалгааны ажлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавьсан болно. Үүнд:

- Уламжлалт ба орчин үеийн хичээлийн технологийг судлах
- Уламжлалт болон орчин үеийн хичээлийн технологийг харьцуулан судалж үнэлгээ дүгнэлт өгөх
- ЕБС-ийн хичээлд анализ хийх аргачлал боловсруулах
- Боловсруулсан аргачлалыг нийтийн хүртээл болгох

Судалгааны шинэлэг тал

ЕБС-ийн багш нарын хичээлд анализ хийх аргачлал боловсруулж түүнийг ажиглаж хичээлийн төвшинд үнэлгээ өгөх нөхцөл бүрдүүлэх

ЕБС-ийн багш нарын хичээлд хийсэн анализ түүний үр дүн

Хүйсийн байдлаар




График 1

Насны байдлаар




График 2

График 3




График 4





График 5



Дүгнэлт

Энэхүү ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд дараах дүгнэлтэнд хүрлээ.

- Хэдийгээр сүүлийн жилүүдэд технологийн шинэчлэл хийгдэж байгаа боловч төдийлөн бид бүхний хүсэн хүлээсэн үр дүнд хараахан хүрээгүй байгаа билээ. 1999 оноос эхлэн сургалтын технологийн шинэчлэл, ээлжит хичээлийн чанар үр дүн зэргүүдээр сургалт семинар их зохиогдож байгаа боловч тодорхой ахиц дэвшил гарахгүй байна.
 - Багшаас үнэлгээ авахын тулд суралцаж буй үзүүлэлт нь зарим сургуулиудаас харьцангуй дээгүүр байгаа нь хичээлийн технологийн шинэчлэлд сургуулиуд анхаардаг нь харагдаж байна.
 - Зарим сургуулиудын суралцагсадын ажиллах арга барил зааж өгч байгаа байдал, орчин үеийн бүтээлч сэтгэлгээний арга, хичээлийн хүмүүжүүлэх үр нөлөөний үзүүлэлтүүд зарим сургуулийнхаас доогуур байна. Уламжлалт арга хэрэглэж байгаа үзүүлэлт сургуулиас доогуур байна.

- Энэ бүх шалгуур үзүүлэлтүүд нь технологийн шинэчлэлийн үр дүнд хангалттай гэж үзэхэд хүрч байна. Тухайлбал: Багш сурагчийн хамтын үйл ажиллагаа, сурагчийн үйл ажиллагаа, сурагчдын хандлага, сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэж буй байдал, хичээлийн чиг хандлагаас 75-аас доогуур үзүүлэлттэй гарч байна.
- Дээрх өгүүлснээс үзэхэд хичээлийн технологийн шинэчлэлийн менежмент төдийлөн хангалттай төвшинд хэрэгжиж чадахгүй байгаа нь харагдаж байна. Ийм учраас зөвхөн сургууль багш нар төдийгүй, багш бэлтгэдэг сургуулийн сургалтанд сургалтын технологийн шинэчлэлийн онол арга зүйн үндсийг авч үзэхийн зэрэгцээ түүний менежментийн асуудлыг тодорхой авч үзэх шаардлагатай гэдэг нь харагдаж байна.